

## ӨРГӨСТ ХЭМХ

### Ач холбогдол



Төмөр, амин дэм С, калци зэргийг агуулсан байдаг учир хоолны шингэц сайжруулах, бөөрний чулуу, шээсний хүчлийн нөлөөгөөр үүсэх талстуудыг эмчлэх үйлчилгээтэй.

**Сорт.** Оросын Ньюох-415, Типличний, Пирин, Израйлын сортуудыг хүлэмжинд тарина. Ил талбайд Алтайский ранний сортыг тариалдаг. Сүүлийн үед Канадаас ирж буй бүдүүн жимстэй сортууд ил талбайд сайн ургаж байна.




**Ургах нөхцөл.** Үрийг хөрсний дулаан 15°-18°С болсон үед суулгана. Хэмх 24 -26 °С дулаантай 80-85% -ийн харьцангуй чийгтэй нөхцөлд хэвийн ургаж 12°С-аас доош дулаан буурвал өсөлт нь зогсдог. Гэрэл чийгэнд дуртай ургамал. Гэрэл дутагдвал иш нь хурдан хөгширч ургац буурдаг. Навчны гадаргуу ихтэй тул чийг их ууршуулж тэр хэмжээгээрээ ус их шаардана. Чийг дутагдвал жимс нь гашуун амттай болох ба жимсний хэлбэр нь муруй тахир болдог

**Тарилт.** Ил талбайн өргөст хэмхийг үрээр, хүлэмжийн өргөст хэмхийг үрслэгээр тариална. Ил талбайн өргөст хэмхийг 25/IV-10/VI-ны хооронд тарина. Хүлэмжийн өргөст хэмхийн үрслэгийн үрийг 20/IV-1/V-ний хооронд суулгаж 20/V-1/VI –ний хооронд хүлэмжинд шилжүүлнэ.

**Үрслэг ургуулах.** Хүлэмж, ил талбайн алинд ч тарьсан тарихын өмнө үрийг заавал соёолуулна. Соёолуулахын тулд 1%-ийн марганцийн уусмалд 10 минут байлгасны дараа 25--30°С халуун усанд 30 минут байлгаад уснаас нь шүүнгүүт даавуунд ороож хоолны халуун саванд хийнэ. Ингэхэд 12-24 цагийн дараа үр жигд соёолсон байна.



	<p>Шигшсэн хар шороо, элс, бууцыг 3:1:4 харьцаатайгаар хольж урьдчилан бэлтгэсэн хайрцаганд хийж халуун усаар зөөлөн услана. Усалсан хөрсний ус жигд нэвчих үед дахин самнаж тэгшлээд 8x8 см 1-2 см гүн хонхорхой гаргаж үрээ суулгана. Суулгасан үрээ 1.5-2 см элсээр хучиж хөрсний чийгийг алдагдуулахгүйн тулд дээрээс нь нийлэг хальсаар бүтээнэ.</p>
	<p>Үр ургаж 2-3 навчтай болох үеийг чихлүүр гэж нэрлэнэ. Энэ чихлүүр буюу жижиг үрслэгийн үед нь чийгийг нь ихдүүлж гэрэл дутаавал үрслэг маш түргэн сунадаг. Үрслэгийг сунгавал амьдрах чадвар нь мууддаг. Сунасан үрслэгийг бага зэрэг манаж өгнө.</p>
	<p>Өвлийн хүлэмжинд 30-45 хоногтой , ил талбай ба зуны хүлэмжинд 21-26 хоногтой үрслэгийг 40x60 см-ийн зайтайгаар шилжүүлэн суулгана. Талбайг 40см-ийн өргөнтэйгээр хоорондоо 60см-ийн зайтайгаар 18-20см -өндөртэйгээр хамарлан засаж усалгааны суваг гаргана. Дараа нь хамар дээгүүр үрслэгийг тогоолж суулгаад ургалтын эхэн үед нь тогоонд 3-5л усаар услана. Эрчимтэй ургах үеэс нь усыг суваг дундуур нь урсаж сувгийг дүүртэл услана.</p>

### Арчилгаа.

	2-3 навчтай үрсэлгээг анхдагч навч хүртэл нь суулгаж усална. Үрсэлгээ суулгасны дараа 7-10 хоноод мөр хоорондхи хог ургамлыг устгаж хөрсийг сийрүүлж өгөхөд хэмх эрчимтэй ургаж эхлэнэ.
	Үрслэгийг суулгаснаас хойш 14 хоногийн дараа усалгаатай хамт анхны бордоо хийж өгнө. Үүнд: Үхрийн нойтон баас, шувууны сангас, малын өтөг бууц зэргийг 100л усанд 20-30кг-аар уусган эсгээд усалгааны өмнө 1 ам метр талбайд 3-4 л-ээр хийж шууд услана. Дараагийн бордоог цэцгийн бундуу үүсэх үед нь дээрхи нормоор бордно
	Өргөст хэмх байнгын жигд усалгааг шаардахаас гадна хэт халуун үед сэрүүцүүлэх усалгаа шаарддаг. Халуун нартай үед өдөр бүр, бороо хуртай сэрүүн бол долоо хоног тутамд нэг удаа сэрүүцүүлэх усалгааг тогтмол хийнэ. Сэрүүцүүлэх усалгаагар 1метр талбайд 2-5 литр ус орохоор бодож зөөлөн шүршиж усална.

### Таналт.

Өргөст хэмхийг ургуулах явцад таналтыг зөв хийх нь жимсийг богино хугацаанд томруулж болцыг гүйцээн ургац нэмэгдүүлэх гол үндэс болно.

	Ургамлын өндөр 15-20см болсон үед тулгуур мод буюу уяагаар гол ишнийг ороож бэхлэнэ. Энэ үеэс таналтыг зөв хийнэ. Үүний тулд ургалтын эхэн үед буюу хөрснөөс дээшхи эхний 5 үе дээр нэг ч салаа мөчир, навч ургуулахгүй тайрна. Зөвхөн гол ишийг ургуулна.
	Газраас дээш 50 см ургах үеэс хажуугийн салааг ургуулж эхлэх ба 6-7-р үе дээр 2 навч нэг жимст цэцэг, дараагийн 2 үе дээр 3 навч 2 жимст цэцэг гэх мэтээр салааны жимсний тоог нэмэгдүүлсээр хэцэнд хүрэхэд хэцийг ороож дараагийн ургамалд хүрэхийн өмнө толгойг доош унжуулна. 5-р үеэс дээш гол ишин дээр ургаж байгаа цэцэг ба жимсийг хэзээ ч тасалж болохгүй. Зөвхөн жимс нь бүрэн боловсорсон үед хураахдаа жимсийг нь авна.

**Хураалт.** 1м.кв талбайгаас 12кг ургац авна. Хүлэмжинд тарьсан өргөст хэмхийн түүвэр хураалтыг талбайд үрслэг суулгасанаас хойш 20-25 хоноод хийж эхэлдэг. Ургах нөхцөлийг бүрэн бүрдүүлж, ургалтын үеийн арчилгааг зөв хийсэн тохиолдолд жимсний гарц илүү сайжирдаг. Үүнийг масс үе гэх ба үед 30 ам метр хүлэмжтэй айл 3-4 хоногт 140-150 кг ургац хураах боломжтой. Хураасан ургацыг 1 хоногоос илүү хугацаагаар хадгалахгүйгээр шууд зах зээлд нийлүүлнэ. Энэхүү ид хураалтын үеэс ургац хурааж дуустал хөрсийг эрчимтэй бордох услах ажлыг тасралгүй хийнэ. Ил талбайд тарьсан өргөст хэмхийг 7-р сарын дунд үеэс түүвэрлэн хураана..